



205  
185

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 106

Есөнбулаг сум

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэн аймгийн хүн амыг эрүүл чанартай хүнсний ногоогоор хангах зорилгоор “Хүлэмж хөтөлбөр”-ийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.


2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөв, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, биелэлтийн явцыг жил бүрийн дөрөвдүгээр улиралд багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА

Т.ГАНЗОРИГ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2017 оны 11 дүгээр сарын 30-ны  
өдрийн 106 дугаар тогтоолын  
01 дүгээр хавсралт



206  
186

## ХҮЛЭМЖ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хүлэмжний үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, хөтөлбөр боловсруулах үндэслэл

Манай аймаг 2016 оны байдлаар аймаг нийт 90 га-д хүнсний ногоо тариалж, 513 тонн ургац хурааж авсан нь дотоодын хүнсний ногооны хэрэгцээний 13 хувийг хангаж байгаа юм. Үлдсэн 87 хувийг хүнсний ногооны хэрэгцээг хөрш зэргэлдээ Ховд аймаг болон Улаанбаатар хотоос авч хангаж байгаа нь хүнсний ногооны аймгийн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатайг харуулж байгаа юм.

Хүнсний ногоог холоос тээвэрлэн хэрэглэгчдэд нийлүүлэхэд хадгалалтын горим алдагдан чанарт өөрчлөлт орох, мөн гарал үүсэл нь тодорхой бус бүтээгдэхүүнийг нийлүүлж байгаа нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцлийг бүрдүүлж байна.

Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт, хүнсний ногооны 60 хувийг аймаг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилт тавин ажиллаж байна.

Энэ зорилтыг хэрэгжүүлэн ажиллахад хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, ялангуяа тариалангийн ил талбай багатай Есөнбулаг, Цээл, Хөхморьт, Баян-Уул, Бугат, Төгрөг, Тонхил, Эрдэнэ сумдад хүлэмжний аж ахуйг илүү хөгжүүлэхээр төлөвлөсөн.

Тус аймагт 10813 м.кв талбай бүхий 109 хүлэмжийг ашиглан, жилд 26.8 тн ургац хураан авч байгаа бөгөөд энэ нь хүнсний ногооны нийлүүлэлтийн 5.2 хувийг эзэлж байна. Цаашид хүнсний ногооны нийлүүлэлтийн 15-20 хувийг хүлэмжинд тариалсан ногоогоор хангах юм.

Шинээр хүлэмжийг байгуулснаар, хүнсний ногооны тариалалт нэмэгдэхийн зэрэгцээ дахин боловсруулалт хийгдэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бүрдэхийн зэрэгцээ ажлын байр шинээр бий болж, хүн амын хүнсний ногооны хэрэглээний нэр төрөл олшрох юм.

Хүлэмжинд тариалах хэмх, лооль, навчит байцайнууд зэрэг хүнсний ногоонууд нь хүний биед юугаар ч орлуулшгүй төрөл бүрийн амин дэм, эрдэс бодисоор нэн баялаг учраас энэ хэрэгцээг хангах шаардлагыг үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийг зорилго:

Аймгийн хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, нэр төрлийг олшруулан хүнсний ногооны нийлүүлтэд хүлэмжний ногооны эзлэх хувийг 20%-д хүргэн, дахин боловсруулалт хийн тариаланчдын борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд оршино.

### Гурав. Хөтөлбөрийн зорилт

- 3.1. Нарны энергиэр, уртасгасан хугацаагаар ажилладаг дулаалгатай хүлэмжийг орон нутагт түгээн дэлгэрүүлэх
- 3.2. Зуны хүлэмжийн хэмжээ, хангамжийг нэмэгдүүлэх
- 3.3 Хүлэмжинд тариалах, өндөр ургац өгөх чадвар бүхий өвчин хортонд тэсвэртэй богино болцтой үрээр тариаланчдыг хангах
- 3.4 Хүнсний ногоог дахин боловсруулах жижиг цех байгуулах, борлуулалтыг дэмжих
- 3.5 Ажиллах хүчний чадавхийг бэхжүүлж, дадлага чадвартай болгох болно.

### Дөрөв. Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ

- 4.1. Нарны энергиэр, уртасгасан хугацаагаар ажилладаг дулаалгатай хүлэмжийг орон нутагт түгээн дэлгэрүүлэх зорилтын хүрээнд:
  - 4.1.1 Орон нутаг дахь материалыг ашиглан, өртөг бага, эдэлгээ удаан нарны энергиэр, уртасгасан хугацаагаар ажиллах дулаалгатай загвар хүлэмжийг бүх сумд барьж ашиглалтанд оруулж ашиглалтыг сайжруулна.
  - 4.1.2 Хүлэмжинд хүнсний ногоо тариалах талбайн хэмжээг 10000 м.кв-д хүргэж үүний 60 хувийг дулаалгатайгаар барьж, 40 хувийг нь зуны улиралд ашиглах хүлэмжийг захиалгын дагуу нийлүүлж хангана.
  - 4.1.3 Хүлэмжний 1 м<sup>2</sup>-ын дундаж ургацыг 7 кг-д хүргэнэ.
  - 4.1.4 Хүлэмжийн тариалан эрхлэх сонирхолтой иргэн аж ахуйн нэгж, байгууллагыг гадаад дотоодын хөрөнгө оруулалт, урт хугацаатай санхүүгийн зээл /сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, аймаг сумын орон нутгийн хөгжлийн сан гэх мэт/- ийн бодлогоор дэмжиж ажиллана.
  - 4.1.5 Нийт хүлэмжийн 35 хувьд нь дуслын усалгааны систем, мананжуулах төхөөрөмж тавьж ашиглана.
- 4.2. Зуны хүлэмжийн хэмжээ, хангамжийг нэмэгдүүлэх хоёрдугаар зорилтын хүрээнд:
  - 4.2.1 Зуны улиралд ашиглах хүлэмжийн захиалгыг тухайн жилийн 2 сарын 1-ний дотор сумдаас авч нэгтгэн нийлүүлэгч байгууллагад хүргүүлнэ.
  - 4.2.2 Захиалсан хүлэмжийг 4 сарын 15-ны дотор нийлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авна.
  - 4.2.3 Шинээр 8000м<sup>2</sup>-аас нийлэг хальсан хүлэмжийг ашиглалтад оруулна.
  - 4.2.4 Зуны хүлэмжнээс нийт ургацын 40 хувийг хураан авна.
- 4.3. Хүлэмжинд тариалах, өндөр ургац өгөх чадвар бүхий өвчин хортонд тэсвэртэй богино болцтой үрээр тариаланчдыг хангах гуравдугаар зорилтын хүрээнд:
  - 4.3.1 Хүлэмжид тариалахад тохиромжтой богино болцтой, ургац өндөр, өвчин хортонд тэсвэртэй сортыг сонгон тариална.
  - 4.3.2 Лоолийн Сибирский скороспелые-1450, Толстой F1, хэмхийн Германы Салдин F1 зэрэг сортуудтай дүйцэхүйц арвин ургац өгөх бусад сортын үрийг, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжид захиалгаар нийлүүлэн

тариалуулна.

4.3.3 Ихээхэн хэмжээгээр тариалалт хийж байгаа иргэн аж ахуйн нэгжид аймгийн ТЭДСангаас үрийн хөнгөлөлт үзүүлнэ.

4.4 Хүнсний ногоог дахин боловсруулах жижиг цех байгуулах, борлуулалтыг дэмжих дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

4.4.1 Өргөст хэмхийг нөөшлөх жижиг оврын цехийг 2 сумд байгуулан, нэмүү өртөг шингэсэн болон экспортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

4.4.2 Хүлэмжинд тариалсан ногоог хатааж боловсруулалт хийх замаар хоол амтлах "Алтайн бренд" бүтээгдэхүүнийг бий болгоно.

4.4.3 Хүлэмжинд тариалсан хүнсний ногоо, дахин боловсруулсан бүтээгдэхүүн, түүгээр хийсэн хоол, зуушийг үзэсгэлэн худалдаа, амталгаат худалдаа зэрэгт оруулж борлуулалтыг дэмжих, туршлага солилцох ажлыг зохион байгуулна.

4.5. Ажиллах хүчний чадавхийг бэхжүүлж, дадлага чадвартай болгох тавдугаар зорилтын хүрээнд:

4.5.1 Хүлэмж барих, хүлэмжинд төрөл бүрийн хүнсний ногоо тариалах, арчлах хураах сургалтыг 9 сумд 200-аас доошгүй иргэнд зохион байгуулна.

4.5.2 Хүлэмжид тариалсан хүнсний ногоогоор төрөл бүрийн хоол хийх сургалтыг 3 сумдыг хамруулан, бүсчлэн зохион байгуулж нийт 3 удаа явуулна.

4.5.3 Хүнсний ногоо хадгалах, боловсруулах зэрэг технологийн сургалтыг 18 сумын хүлэмжийн аж ахуй эрхлэгчид болон сонирхсон бизнесийн төлөөллийг оролцуулан хийнэ.

4.5.4 Есөнбулаг сумд аймгийн загвар хүлэмжийг байгуулж иргэдийг сургах зөвлөгөө мэдээлэл, туршлага солилцуулах агропарк болгон ажиллуулна.

4.5.5 Хүлэмжийн тариалан эрхлэгчдийг гадаад, дотоодын техник тоног төхөөрөмжийн үзэсгэлэн худалдаа, туршлага судлах сургалт, аялалд оролцуулна.

#### Тав.Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана.

5.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалт;

5.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;

5.3 Дотоод, гадаадын иргэн, хуулийн этгээдийн өөрийн хөрөнгө;

5.4 Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сан, банкны зээл;

5.5 Тариалан эрхлэлтийг дэмжих сан

5.6 Гадаад улс, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл.

#### Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, зохицуулах чиг үүргийг аймгийн ЗДТГ, ХХААГ хэрэгжүүлнэ. Сумдад сумын ЗДТГ хариуцан хэрэгжүүлнэ.

269  
189

- 6.2 Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөв, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс тусгаж хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллана.
- 6.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчаас сумын Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тусгуулан хамтарч ажиллана.

Долоо.Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт шинжилгээ үнэлгээ хийх

- 7.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, гүйцэтгэсэн ажлын тайланг жил бүрийн 4 дүгээр улиралд гарган аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст өгч үнэлгээ хийлгүүлнэ.
- 7.2 Хөтөлбөрт хийсэн үнэлгээний дүнг аймгийн засаг даргын зөвлөл болон аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэрүүлэгчдэд танилцуулж байна.

Найм. Хөтөлбөр хэрэгжих хугацаа:


2017-2020 он

Ес. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

1. Нийт 20000 м<sup>2</sup>-аас доошгүй талбайд хүлэмжийн ногоо тариалж, 200-аас доошгүй тн ургац хураан авч хүнсний хэрэгцээнд нийлүүлнэ.
2. Хүнсний ногоо нөөшлөх цех 2-ыг барьж ашиглалтанд оруулна.
3. Хүнсний ногоог хатаах технологиор боловсруулж хоол амтлагч болон бусад төрлийн бүтээгдхүүнийг үйлдвэрлэнэ.

----oOo----

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны  
11 дүгээр сарын 30-ны өдрийн 106 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт



Хүлэмж хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө

Д.д	Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Санхүүжилт		Хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
				Эх үүсвэр	хөрөнгийн хэмжээ сая. төг			
1	Уртасгасан хугацаат, нарны энергиэр ажилладаг хүлэмжийг сумдад түгээн дэлгэрүүлэх	Хүлэмжийг барих сургалт хийн загвар хүлэмжийг сумдад барьж өгөх	10 суманд хүлэмж баригдсан байна.	АОНХС, СОНХС, ТЭДС	35.0	2018-2020	ХХААГ	АЗДТГ, Сумдын ЗДТГ
2	Хүлэмжийн тариалах талбайн хэмжээг 20000 м.кв талбайгаар нэмэгдүүлнэ	Нийт хүлэмжийн 60 хувийг нь дулаалгатай хүлэмж, 40 хувийг нь зуны улиралд ашиглах нуман хүлэмжийг захиалгын дагуу нийлүүлж хангана.	дулаалгатай хүлэмжийн талбайг 12000 м2-д хүргэж 48.0 тн ургац хураан авна.	АОНХС, СОНХС, ТЭДС, төсөл, хөтөлбөр	325.0	2018-2020	ХХААГ	АЗДТГ, Сумдын ЗДТГ
			Солонгос улсын 120 м.кв талбай бүхий 67 хүлэмжийг захиалгын дагуу нийлүүлж тариалалт хийж, 24 тн ургац хураан авна.	АОНХС, СОНХС, ТЭДС	216.0	2018-2020	ХХААГ	АЗДТГ, Сумдын ЗДТГ

06/10/17

3	<p>оруулалт, урт хугацаатай санхүүгийн зээл /сүм хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, СОНХС гэх мэт/ ийн бодлогоор</p>	<p>Сум хөгжүүлэх сангийн зээлийн 15%, СОНХСангийн 5% нь, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээлийн 8% ийг тус тус хүлэмжний аж ахуйг хөгжүүлэхэд</p>	<p>Хөтөлбөрт тусгагдсан зорилг бүрэн хэрэгжсэн байна</p>	<p>АОНХС, СОНХС, ТЭДС</p>
4	<p>Усыг ариг намтай зарцуулах технологи нэвтрүүлж, арвин ургацтай сортын үрээр хангах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Нийт хүлэмжний 35%-д нь буюу 73 хүлэмжид дуслын усалгааны систем, мананжуулах төхөөрөмжийг суурилуулж ашиглана.</p>	<p>Усыг хэмнэлттэй зарцуулах технологийг нэвтрүүлнэ.</p>	<p>СОНХС</p>
4		<p>Хүлэмжинд тарилахад тохиромжтой богино болцтой, ургац өндөр, өвчин хортонд тэсвэртэй сортын үрээр хүлэмж эрхлэгчдийг хангана</p>	<p>Нутагшсэн 3-4 сортоор тариалалт хийдэг болсон байна.</p>	<p>СОНХС ТЭДС</p>
	<p>Хүнсний ногоо боловсруулах бага</p>	<p>Есөнбулаг сумд хүнсний ногоо хатаах бага оврын үйлдвэр байгуулна</p>	<p>Экспортыг орлох бүтээгдхүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ.</p>	<p>СОНХ, СХС</p>

210.0	2017-2020	ХХААГ	АЗДТГ, Сумдын ЗДТГ
73.0	2017-2021	ХХААГ	Сумдын ЗДТГ иргэд, ААН
15.0	2017-2022	ХХААГ	Сумдын ЗДТГ, иргэд ААН
	2018-2020	ХХААГ	өнбулаг сумын ЗД

15/11/20